

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд суламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хууль: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/162

танай _____-ны № _____-г

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БАЯР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой тус байгууллагаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А-1/1755 тоот албан бичгийг үндэслэн нийт 337,09 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэснээр нийт хөрөнгө 5.8 дахин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Ебаримт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 23 ширхэг 55,3 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 3 ширхэг 8,7 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, төгрөгийн баталгаажуулаагүй буцаалтын зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроосон ба 3 тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

010033020

Үлдэх өртөггүй 14 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй.

Тус байгууллагын бүтэц орон тоогоор Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан гэдэг орон тоо батлагдаагүй боловч 12-р сард уг албан тушаалд 1 хүн томилж, албан тушаалын үндсэн цалинг 30% ийн нэмэгдүүлэн олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,557,008.00	46,179,885.20
33	АВЛАГА	821,783.00	1,075,783.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	565,000.00	819,000.00
335	Бусад авлага	256,783.00	256,783.00
3351	Байгууллагаас авах авлага	256,783.00	256,783.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,735,225.00	45,104,102.20
351	Түүхий эд материал	442,306.00	27,311,786.20
35110	Тусгай зориулалттай материал	442,306.00	11,570,306.00
35130	Эм боох материал	0	15,741,480.20
354	Хангамжийн материал	12,292,919.00	17,792,316.00
35410	Бичиг хэргийн материал	1,715,920.00	2,494,150.00
35420	Аж ахуйн материал	9,031,999.00	13,200,089.00
35430	Сэлбэг хэрэгсэл	240,000.00	175,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,305,000.00	1,280,000.00
35460	Хүнсний материал	0	643,077.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	58,427,988.40	376,520,269.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	58,427,988.40	376,520,269.78
392	Биет хөрөнгө	58,227,988.40	345,784,269.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	0	226,874,609.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-2,850,945.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,000,000.00	53,111,381.46
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,000,000.00	-22,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,230,367.00	29,644,933.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,788,287.69	-13,405,874.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,578,756.00	22,318,773.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,297,954.99	-9,854,088.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,165,500.00	70,398,055.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,195,391.92	-8,987,575.03
39217	Ном	535,000.00	535,000.00
393	Биет бус хөрөнгө	200,000.00	30,736,000.04
39301	Програм хангамж	200,000.00	348,848.88
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-188,848.84
39303	Бусад биет бус хөрөнгө		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	71,984,996.40	422,700,154.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	68,750.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	68,750.00
413	Өглөг	0	68,750.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	68,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	71,984,996.40	422,631,404.98
51	Засгийн газрын хувь оролцоо	71,984,996.40	422,631,404.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80,033,794.00	80,033,794.00
51101	Өмч: - төрийн	80,033,794.00	80,033,794.00
512	Хуримтлагдсан үр дүн	-8,563,123.47	342,083,285.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-8,563,123.47	-8,563,123.47
51220	Тайлант үеийн үр дүн	0	350,646,408.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	514,325.87	514,325.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	71,984,996.40	422,700,154.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	259,125,678.00	804,859,709.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	146,968,278.00	466,137,984.02
120	Нийтлэг татварын бус орлого	146,968,278.00	466,137,984.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	146,691,798.00	440,390,899.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,671,310.00	103,292,920.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	43,020,488.00	337,097,979.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	276,480.00	25,747,085.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	112,157,400.00	338,721,725.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,157,400.00	330,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,157,400.00	330,301,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	8,420,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	8,420,625.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	224,979,903.38	454,213,300.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,979,903.38	454,213,300.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,848,140.87	391,623,388.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,009,164.42	266,056,979.14
210101	Үндсэн цалин	90,331,076.92	184,775,081.90
210102	Нэмэгдэл	13,811,973.50	57,007,417.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,566,114.00	11,833,000.00
210104	Урамшуулал	300,000.00	12,441,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,382,290.07	33,165,956.39
210201	Тэтгэврийн даатгал	8,401,300.27	22,782,139.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,850,668.29	1,936,520.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	863,392.36	1,685,485.08
210204	Ажилгүйдлийн даатгал	206,084.43	1,621,093.67
210205	Эрүүл мэндийн даатгал	2,060,844.72	5,140,716.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,948,211.00	32,311,578.70
210301	Гэрэл, цахилгаан	775,859.00	915,467.70
210302	Түлш, халаалт	11,619,080.00	25,039,199.00
210303	Цэвэр, бохир ус	553,272.00	690,912.00
210304	Байрны түрээс	0	5,666,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,767,676.00	15,293,769.60
210401	Бичиг хэрэг	2,971,390.00	3,746,450.00
210402	Тээвэр, шатахуун	6,058,800.00	6,025,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,848,036.00	2,907,989.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	769,450.00	1,858,030.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	756,300.00
2105	Нормативт зардал	2,650,797.00	5,888,516.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,076,985.00	3,860,474.80
210502	Хоол, хүнс	573,812.00	2,028,042.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,870,150.00	4,589,390.00
210604	Урсгал засвар	1,870,150.00	4,589,390.00
2107	Томилолт, зочны зардал	11,894,800.00	12,199,000.00
210702	Дотоод албан томилолт	11,894,800.00	12,199,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	290,500.00	353,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	320,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,000.00	3,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,034,552.38	21,765,197.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,014,399.00	2,039,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	720,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,800,153.38	19,005,697.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,131,762.51	62,589,912.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,931,762.51	47,189,912.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,931,762.51	47,189,912.17
213304	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,000,000.00	15,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,000,000.00	15,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>34,145,774.62</u>	<u>350,646,408.58</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,043,286.62</u>	<u>350,646,408.58</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>217,676,710.00</u>	<u>441,760,645.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,519,310.00	103,038,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,519,310.00	103,038,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,519,310.00	103,038,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,519,310.00	103,038,920.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	112,157,400.00	338,721,725.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,157,400.00	330,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,157,400.00	330,301,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	8,420,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	8,420,625.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>217,676,710.00</u>	<u>441,760,645.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,676,710.00	441,760,645.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164,544,947.49	377,996,055.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,009,164.42	266,056,979.14
210101	Үндсэн цалин	90,301,577.92	181,756,547.26
210102	Нэмэгдэл	13,841,472.50	57,256,116.73

210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,566,114.00	14,193,000.00
210104	Урамшуулал	300,000.00	12,851,315.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,382,290.07	33,097,206.39
210201	Тэтгэврийн даатгал	9,172,728.08	22,617,989.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,079,240.48	2,651,607.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	863,392.36	2,125,460.48
210204	Ажилгүйдлийн даатгал	206,084.43	513,731.85
210205	Эрүүл мэндийн даатгал	2,060,844.72	5,188,416.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,060,211.00	32,331,578.70
210301	Гэрэл, цахилгаан	775,859.00	915,467.70
210302	Түлш, халаалт	11,619,080.00	25,039,199.00
210303	Цэвэр, бохир ус	665,272.00	710,912.00
210304	Байрны түрээс	0	5,666,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,397,685.00	12,765,921.60
210401	Бичиг хэрэг	1,530,700.00	2,096,680.00
210402	Тээвэр, шатахуун	2,961,800.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,894,536.00	3,069,609.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	890,649.00	1,599,632.00
2105	Нормативт зардал	2,076,985.00	7,715,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,076,985.00	7,715,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	887,400.00	5,999,800.00
210604	Урсгал засвар	887,400.00	5,999,800.00
2107	Томилолт, зочны зардал	11,894,800.00	12,199,000.00
210702	Дотоод албан томилолт	11,894,800.00	12,199,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,155,500.00	668,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	320,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,000.00	3,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	895,000.00	315,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,680,912.00	7,161,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,460,912.00	5,981,810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	1,180,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,131,762.51	63,764,589.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	1,574,677.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,574,677.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,931,762.51	47,189,912.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,931,762.51	47,189,912.17
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,000,000.00	15,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,000,000.00	15,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-42,606,410.09	37,941,709.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-42,606,410.09	37,941,709.78
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,043,286.62	34,043,286.62
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-8,563,123.47	71,984,996.40
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-8,563,123.47	71,984,996.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-8,563,123.47	71,984,996.40
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	350,646,408.58	350,646,408.58
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	342,083,285.11	422,631,404.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	410,301,100.00	432,443,410.00	-22,142,310.00	105%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	410,301,100.00	432,443,410.00	-22,142,310.00	105%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,699,100.00	368,678,820.83	40,020,279.17	90%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,414,300.00	258,571,979.14	29,842,320.86	90%
210101	Үндсэн цалин	190,794,200.00	175,284,794.76	15,509,405.24	92%
210102	Нэмэгдэл	70,678,000.00	56,242,869.23	14,435,130.77	80%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,184,500.00	14,193,000.00	991,500.00	93%
210104	Урамшуулал	11,757,600.00	12,851,315.15	-1,093,715.15	109%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,051,700.00	32,161,581.39	3,890,118.61	89%
210201	Тэтгэврийн даатгал	24,515,200.00	21,981,764.91	2,533,435.09	90%
210202	Тэтгэмжийн даатгал	2,884,100.00	2,576,757.29	307,342.71	89%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,307,300.00	2,065,580.48	241,719.52	90%
210204	Ажилгүйдлийн даатгал	576,800.00	498,761.85	78,038.15	86%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,768,300.00	5,038,716.86	729,583.14	87%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,085,800.00	32,331,578.70	754,221.30	98%
210301	Гэрэл, цахилгаан	1,016,000.00	915,467.70	100,532.30	90%
210302	Түлш, халаалт	25,584,000.00	25,039,199.00	544,801.00	98%
210303	Цэвэр, бохир ус	819,000.00	710,912.00	108,088.00	87%
210304	Байрны түрээс	5,666,800.00	5,666,000.00	800.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	12,903,300.00	12,765,921.60	137,378.40	99%
210401	Бичиг хэрэг	2,100,000.00	2,096,680.00	3,320.00	100%

210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,083,300.00	3,069,609.60	13,690.40	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000.00	1,599,632.00	368.00	100%
2105	Нормативт зардал	7,740,000.00	7,715,760.00	24,240.00	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,740,000.00	7,715,760.00	24,240.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,999,800.00	200.00	100%
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,999,800.00	200.00	100%
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00	12,199,000.00	2,801,000.00	81%
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	12,199,000.00	2,801,000.00	81%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,188,000.00	668,000.00	1,520,000.00	31%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,820,000.00	320,000.00	1,500,000.00	18%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,000.00	3,000.00	0.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	0.00	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	315,000.00	315,000.00	0.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7316000	6,265,200.00	1,050,800.00	86%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,136,000.00	5,085,200.00	1,050,800.00	83%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,180,000.00	1,180,000.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1602000	1574677	27323	98%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,602,000.00	1,574,677.00	27,323.00	98%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,602,000.00	1,574,677.00	27,323.00	98%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	410,301,100.00	433,340,020.00	-23,038,920.00	106%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330,301,100.00	330,301,100.00	0.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	330,301,100.00	330,301,100.00	0.00	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,000,000.00	103,038,920.00	-23,038,920.00	129%
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000,000.00	103,038,920.00	-23,038,920.00	129%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,420,625.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,420,625.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,420,625.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,485,000.00
210101	Үндсэн цалин	6,471,752.50
210102	Нэмэгдэл	1,013,247.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	935,625.00
210201	Тэтгэврийн даатгал	636,225.00
210202	Тэтгэмжийн даатгал	74,850.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,880.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,970.00
210205	Эрүүл мэндийн даатгал	149,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8420625
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,420,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,420,625.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Стандарт хэмжил зүйн газрын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, зохицуулалтаар хангагдаж, стандарт, тохирлын үнэлгээ, баталгаажуулалт, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах аймгийн Засаг даргын дэргэдэх тохируулагч агентлаг юм. Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор Стандарт, хэмжил зүйн хэлтэс болон нэр өөрчлөгдсөн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорноговь аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаа нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулиудын эрх зүйн орчинд явагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Засгийн газрын 2023 оны 6-р сарын 21 өдрийн 241 тоот тогтоол Төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Нягтлан бодогч өөрөө санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлдэг учраас үр нөлөө багатай гэж үзлээ.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн/нийцээгүй*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай*.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 350.7 сая төгрөгөөр буюу 5.8 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	821,7	1,075,7	254,0
Урьдчилгаа			
Бараа материал	12,735.2	45,104.1	32,368.8
Үндсэн хөрөнгө	58,427.9	376,520.2	318,092.2
Нийт хөрөнгө	71,984.9	422,700.1	350,715.1
Өр төлбөр	00.00	68.7	68.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	71,984.9	422,631.4	350,646.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	71,984.9	422,700.1	350,715.1

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой тус байгууллагаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А-1/1755 тоот албан бичгийг үндэслэн нийт 337,09 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэснээр үндсэн хөрөнгө 6.4 дахин нэмэгдсэн байна.

Мөн тусгай материал, эм боох материал дансанд мэргэжлийн хяналтын газраас 25,7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 330.3 сая, үйл ажиллагааны орлогоос 80 сая, нийт зарлагыг 410,3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 330.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 103.03 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 330.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 103 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Үндсэн төсөл хөтөлбөр	410,301.1	433,340.	23,0	106%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн 8.4 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж Цалин нийгмийн даатгалд зарцуулсан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах 4 холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интакс Эксперт Ди Си ХХК газрын ахлах аудитор Д.Сайнжаргал, аудитор Б.Болормаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, газрын захирал, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны аудитлагдсан тайлангийн нийт зардлын үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны аудитлагдсан тайлангийн нийт зардлын үзүүлэлтийн 224,979.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,499.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийн хэтрэлгүй байх зэрэг арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн босоо шинжилгээг хийж үзэхэд батлагдсан төсөв хэтрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроосон ба 3 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 23 ширхэг 55,3 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 3 ширхэг 8,7 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, төгрөгийн баталгаажуулаагүй буцаалтын зөрчилтэй байлаа.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дорноговь аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,223.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 40,662.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 23,560.6 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Үнэ төлбөргүй худалдан авсан бараа материалыг үндсэн хөрөнгийн орлогод авсан алдаа, нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө стандартын заалт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа
- Үнэ төлбөргүй авсан бараа материалын дүн нь үр дүнгийн тайланд тайлагнасан дүнгээс 528,8 төгрөгөөр зөрсөн зөрчил илэрсэн дансны эдийн засгийн ангилал, худалдан авалтын горим сольж бүртгэсэнтэй холбоотой алдаа, УСНББОУС-17 үндсэн хөрөнгө стандартын заалт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан алдаа нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

Аудитаар нийт 23,560.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 23,560.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 23,560.6 мянган төгрөгийг зөрчлөөс хуулийн хэрэгжилттэй холбоотой 23,560.6 мянган төгрөгийн зөрчлийн дүнг хасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 330.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт хүргүүлээгүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй .

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Тус байгууллагын бүтэц орон тоогоор Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан гэдэг орон тоо батлагдаагүй боловч 12-р сард Шинэчимэгийг уг албан тушаалд томилж, албан тушаалын үндсэн цалинг 30% ийн нэмэгдүүлэн олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн захирагчийн баталсан бүтэц орон тоог барьж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Үлдэх өртөггүй 14 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам 7.1-ийг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй худалдан авсан бараа материалыг үндсэн хөрөнгийн орлогод авсан	1	113.80					1	113.80				
Үнэ төлбөргүй авсан бараа материалын дүн нь үр дүнгийн тайланд тайлагнасан дүнгээс 528 812 төгрөгөөр зөрсөн зөрчил илэрсэн дансны эдийн засгийн ангилал, худалдан авалтын горим сольж бүртгэсэнтэй холбоотой байна.	1	528.81					1	528.81				
Төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасныг залруулав.	1	40,020.28					1	40,020.28				
Дүн	3	40,662.9						40,662.90				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын бүтэц орон тоогоор Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан гэдэг орон тоо батлагдаагүй боловч 12-р сард 1 ажилтанг уг албан тушаалд томилж, албан тушаалын үндсэн цалинг 30% ийн нэмэгдүүлэн олгосон байна.	1	330.00					1	330
Үлдэх өртөггүй 14 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй.	1						1	-
Дүн	2	330.00	-	-	-	-	2	330.00

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроосон ба 3 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	14,523.00					1	14,523.00
ДҮН	1	14,523.00					1	14,523.00
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 23 ширхэг 55,3 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 3 ширхэг 8,7 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, төгрөгийн баталгаажуулаагүй буцаалтын зөрчилтэй байлаа.	1	8,707.67					1	8,707.67
ДҮН	1	8,707.67					1	8,707.67